



НИЙСЛЭЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ШАШНЫ БАЙГУУЛЛАГУУД

Н.Байгалмаа
НСГ-ын мэргэжилтэн

Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм, хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох ажил 1994 оноос хэрэгжиж эхэлсэн. “Төр, сүм хийдийн харилцааны тухай” хуулийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд хангуулах ажлын хүрээнд шашны байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах тухай журмыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 52 дугаар тогтоолоор анх баталж байсан байна.

1993 онд батлагдсан “Төр, сүм хийдийн харилцааны тухай” Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйл, нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм, хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох тухай журмыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гаргаж, зөвшөөрөл шинээр олгох, зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж ирсэн.

Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй нийт сүм хийд, цуглааны тоо 2002 онд 85, 2006 онд 133, 2009 онд 183 байсан бол 2011 оны эцэст 247-д хүрээд байна.¹

Хүснэгт 1. Зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо, шашны төрөл, дүүргээр, 2011 оны эцэст

Дүүрэг	Бүгд	Шашны төрлөөр:					
		Будда	Христ	Католик	Бөө	Ислам	Бусад*
Багануур	4	2	2	-	-	-	-
Баянгол	35	22	12	1	-	-	-
Баянзүрх	71	15	51	2	2	-	1
Налайх	4	1	2	-	-	1	-
Сонгинохайрхан	45	15	27	-	2	1	-
Сүхбаатар	39	10	22	1	4	-	2
Хан-Уул	18	8	8	2	-	-	-
Чингэлтэй	31	8	16	-	7	-	-
Нийслэлийн дүн	247	81	140	6	15	2	3

НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 1994 оноос хойш шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан нийт сүм хийдийн 56.7 хувийг христийн, 32.8 хувийг буддын шашин эзэлж байна. Үүний дотор нийслэлийн Баянзүрх дүүрэгт хамгийн олон сүм хийд төвлөрч зөвшөөрөлтэй нийт сүм хийдийн 28.7 хувь, христийн шашны 36.4 хувь нь тус дүүрэгт бүртгэлтэй байна. Удаад нь Сонгинохайрхан дүүрэг орж байгаа бөгөөд нийт сүм хийдийн 18.2 хувь, христийн шашны 19.3 хувь, буддын шашны 18.5 хувь нь тус дүүрэгт бүртгэгдсэн байна.

¹ Мэдээллийн эх сурвалж: НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2000-2011 онуудын тогтоол, шийдвэр
* Бахай, Мүүний болон Шинто шашин

Дээрх мэдээлэл зөвшөөрөлтэй сүм хийдийн 46.9 хувь, христийн сүмүүдийн 55.7 хувь нь зөвхөн энэ хоёр дүүрэгт төвлөрсөн байгаагаас үзэхэд орон нутгаас шилжин ирж сууршигч ихтэйд тооцогддог гэр хороололд уламжлалт бус шашны байгууллагууд харьцангуй олноор байршдаг болохыг харуулж байгаа юм.

Бөө мөргөлийн зан үйл үйлддэг бөөгийн шашны 15 байгууллага нийслэлд бүртгэгджээ. Хамгийн анхных нь нийслэлийн Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт “Баяннамсрай” нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 1998 оны 12-р сарын 16-ны өдрийн 95-р тогтоолоор үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл нь олгогдон өнөөг хүртэл тогтвортой ажилласаар ирсэн ба 2003 онд нэрээ “Мөнх тэнгэрийн төгс гэгээрлийн шид бөө мөргөлийн онгон шүтээний төв” болгон өөрчилсөн.

Нийслэлийн Налайх, Сонгинохайрхан дүүрэгт исламын шашны 2 байгууллага бүртгэгдэн үйл ажиллагаа явуулж байна. Налайх дүүрэгт байрлах Мекке сүм нь лалын шашны хоёр үндсэн урсгалын томоохон нь болох суннит (*sunnite*) чиглэлийг баримталдаг бөгөөд шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа нь “байнга” гэсэн тодотголтойгоор 1994 онд олгогдсон байдаг. Харин исламын шашны хоёр дахь төлөөлөл болсон Өмермечет² сүмд НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 11-р сарын 18-ны өдрийн 149-р тогтоолоор зөвшөөрөл олгож, Сонгинохайрхан дүүрэгт байршин үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Христийн шашны томоохон салбаруудын нэг католик шашны талаарх тоо мэдээллийг энд тусад нь салгаж харуулахыг зорьсон болно. Монгол дахь Католик сүмд НИТХ-ын Тэргүүлэгчдийн 1998 оны 6-р сарын 10-ны өдрийн 49-р тогтоолоор анх зөвшөөрөл олгож, үйл ажиллагаа нь албан ёсоор эхэлсэн байдаг. 2011 оны эцэст нийслэлийн хэмжээнд Монгол дахь Католик сүмийн харьяа 4 салбар сүм бүртгэгдээд байгаа ба эдгээр нь нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт байна.

Зураг 1. Тогтвортой үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, дүүргээр, 2011 оны эцэст



Нийслэлийн нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй нийт сүм хийдээс 135 нь буюу 54.7 хувь нь 2011 онд “тогтвортой үйл ажиллагаа” явуулжээ. Ийнхүү тогтвортой үйл ажиллагаа явуулсан гурван сүм хийд тутмын нэг нь нийслэлийн Баянзүрх дүүрэгт ногдож байгаа юм. Өөрөөр хэлбэл, Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн нийт сүм хийдийн 63.4 хувь, Баянгол дүүргийн 60.0 хувь, Хан-Уул дүүргийн 50.0 хувь, Сонгинохайрхан дүүргийн 48.9 хувь, Сүхбаатар дүүргийн 48.7 хувь, Чингэлтэй дүүрэгт бүртгэлтэй сүм хийдийн 41.9 хувь нь тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн гэсэн үг юм.

² Мечет (mosque) Лалын шашинтнуудын нийтээрээ цугларч мөргөл үйлддэг сүм, Britannica ширээний нэвтэрхий толь, 4, 2005 дахь тал.

Үйл ажиллагаа нь тогтмолжсон сүм хийдүүдийг шашны төрлөөр нь авч үзэхэд ихэнх буюу 66.7 хувийг христийн шашин эзэлж байгаа бол 26.7 хувийг буддын, 1.5 хувийг исламын, 0.7 хувийг католик, 2.2 хувийг бөөгийн болон бусад шашны төлөөлөл тус тус эзэлж байна.

Дээрх мэдээллээс харахад манай нийгмийн оюун санааны амьдралд хийгээд иргэдийн шашны боловсролын асуудалд христийн шашны эзлэх байр суурь нэмэгдэх чиг хандлагатай болж ирснийг илэрхийлэхийн сацуу нөгөө талаар тэднийг хөрөнгө, санхүүгийн хувьд ивээн тэтгэж, дэмжлэг үзүүлдэг сүсэгтнүүд, үйл ажиллагааг нь санхүүжүүлэгч гадаадын найдвартай түншүүдтэй нь холбон тайлбарлаж болох юм.

Хүснэгт 2. Тогтвортой ажилласан сүм хийд, шашны төрөл, дүүргээр, 2011 оны эцэст

Дүүрэг	Бүгд	Шашны төрлөөр:						Зөвшөөрөлтэй сүм хийдэд эзлэх хувь
		Будда	Христ	Католик	Бөө	Ислам	Бусад*	
Багануур	3	1	2	-	-	-	-	75.0
Баянгол	21	11	8	-	2	-	-	60.0
Баянзүрх	45	8	35	1	-	-	1	63.4
Налайх	3	1	1	-	-	1	-	75.0
Сонгинохайрхан	22	6	15	-	-	1	-	48.9
Сүхбаатар	19	2	14	-	1	-	2	48.7
Хан-Уул	9	3	6	-	-	-	-	50.0
Чингэлтэй	13	4	9	-	-	-	-	41.9
Нийслэлийн дүн	135	36	90	1	3	2	3	54.7
Зөвшөөрөлтэй сүмд эзлэх хувь	54.7	44.4	64.3	16.7	20.0	100.0	100.0	

Үйл ажиллагаа нь хэвийн бөгөөд тогтвортой ажиллаж буй сүм хийдүүдийг шашны төрлөөр нь ангилан, албан ёсны зөвшөөрөлтэй тухайн шашны төрөлд эзлэх хувийн жин, дүүрэг тус бүрээр нь харьцуулан гаргаж хүснэгтээр харуулав.

Нийслэлийн хэмжээнд шашны үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдээд байгаа ислам, бахай, мүүнийн болон шинто шашны төлөөллүүд бүгд 100 хувь үйл ажиллагаа явуулсан байна. Харин бөө мөргөлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан таван шашны байгууллага тутмын нэг нь үйл ажиллагаагаа тогтмол явуулжээ. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлсэн буддын шашны байгууллагуудын зөвшөөрөлтэй сүм хийддээ эзлэх хувийн жин нь 44.4 байгаа бол христийн шашных тэдгээрээс 19.9 пунктээр илүү буюу 64.3 хувьтай гарч байна. Зөвшөөрөл бүхий католик шашны сүмүүдэд тогтмол үйл ажиллагаа эрхэлсэн сүмүүдийн эзлэх хувь хамгийн бага буюу 16.7 байгаа нь төв сүмээсээ санхүүжилттэй, тайлан баланс нь нэгдмэл гардаг гол төлөв салбар сүмүүд байдагтай холбоотой.


Дээрх үзүүлэлтийг нийслэлийн дүүрэг тус бүрээр харьцуулан гаргахад зөвшөөрөлтэй сүмд тогтмол үйл ажиллагаатай сүмүүдийн эзлэх хувь хэмжээгээр Чингэлтэй дүүрэг нэлээд доогуур буюу 41.9 хувьтай байна. Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргүүдийнх ойролцоо байхад Хан-Уул дүүргийнх 50.0 хувьтай байгаа юм.

Нийслэлийн алслагдсан дүүргүүдээс Багахангай дүүрэгт ямар нэгэн шашны байгууллага бүртгэгдэж, үйл ажиллагаа явуулдаггүй, харин Багануур, Налайх дүүргийн хувьд зөвшөөрөлтэй сүмд тогтмол үйл ажиллагаатай сүмүүдийн эзлэх хувийн жин нь харьцангуй өндөр буюу тус бүр 75.0 хувьтай байгаа нь тухайн дүүргүүдэд бүртгэгдэн үйл ажиллагаа явуулдаг шашны байгууллагууд бүхэлдээ цөөхөн байдгаас шалтгаалсан байна.

Хэдийгээр шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй боловч тодорхой шалтгааны улмаас тогтвортой ажиллаж чадаагүй байгууллагууд нэлээд байна. Тухайлбал, газар эзэмших зөвшөөрлийн асуудал нь олон жил шийдэгдэлгүй удааширсан тул үйл ажиллагаа огт явуулалгүй замхарсан, үйл ажиллагаа нь жигдэрч амжаагүй эсвэл түр болон бүр мөсөн зогссон, зөвхөн маань, уншлага унших төдийгөөр хязгаарлагддаг газрууд цөөнгүй байна. Мөн түүнчлэн шашин, уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх, бясалгал, бөө, сүнсний тухай ойлголтыг шинжлэх ухааны талаас таниулах зэрэг танин мэдэхүйн чиглэлээр төрийн бус байгууллагын хэв шинжээр ажилладаг, библийн сургалт явуулдаг гэх мэт шашны бус үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд тодорхой хувийг эзэлж байгааг энд дурдах нь зүйтэй болов уу.

Судалгааны дараагийн хэсэгт шашны байгууллагуудын талаар сүүлийн 12 жилийн туршид гаргасан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолуудын бүтцийн талаар авч үзэх болно. Тодруулбал, нийслэлийн нутаг дэвсгэрт нэг жилд хичнээн сүм хийд шинээр байгуулагдаж, тэдгээрээс хэд нь шашны ямар төрөл, урсгалыг төлөөлж буйг, мөн хичнээн сүм хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгасан гэх мэт мэдээллүүд багтсан юм.

Зураг 2. Сүм хийдэд зөвшөөрөл олгосон НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, 2000-2011 он



Зурагт үзүүлсэн мэдээллээс харахад нийслэлд байршилтай шашны байгууллагуудын үйл ажиллагаа 2006 оноос нэлээд идэвхжиж эхэлсэн гэж үзэж болохоор байна. Учир нь 2005 он хүртэл нэг жилд дээд тал нь 30 гаруй сүм хийд, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацаагаа сунгуулж ажилласан байхад энэ үзүүлэлт 2006-2008 онуудад 50 гаруйд хүрч, 2009 онд улам нэмэгдэж 78 болсон бөгөөд 2011 оны эцэст 121 болж өмнөх оныхоос 39.1 хувиар өссөн байна. Энэ нь 2000 оныхтой харьцуулахад 7.5 дахин, 2005 оныхоос 3.3 дахин өссөн гэсэн үг юм.

Харин шинээр байгуулагдсан сүм хийдийн тоо хэмжээ дурдаж буй хугацаанд харилцан адилгүй дүнтэй байна. 2004 онд нийслэлд 26 сүм хийд шинээр үүсгэн байгуулагдаж байсан бол хамгийн олноор байгуулагдсан тохиолдол 2010 онд болж, 42 сүм хийд шинээр байгуулагдан, зөвшөөрөл авч байжээ.

Хүснэгт 3. Шинээр байгуулагдсан сүм хийд, шашны төрлөөр

Он	Бүгд	Шашны төрлөөр:					
		Будда	Христ	Католик	Бөө	Ислам	Бусад
2011	22	4	17	1			
2010	42	9	29	1	3		
2009	16	5	7		3	1	
2008	18	8	9		1		
2007	8	2	4		2		
2006	18	7	10		1		
2005	9	2	7				
2004	26	7	17	1	1		
2003	10	8	2				
2002	7	4	2	1			
2001	5	3	1		1		
2000	11	4	6				1

Нийслэлийн нутгын өөрөө удирдах ёсны байгууллагын зүгээс сүм хийдэд зөвшөөрөл олгохдоо уламжлалт бурханы шашин хийгээд уламжлалт бус шашны байгууллагууд хоорондын тооны харьцааг “харилцан тэнцвэртэй” байлгах чиг баримталж ирсэн хэдий ч энэ бодлого 2000 оны дунд үеэс алдагдаж эхэлсэн байна. Тухайлбал, 2004 онд зөвшөөрөл шинээр олгосон сүм хийдийн 65.4 хувийг дан ганц христийн сүмүүд эзэлж байв.

Энэ байдал 2007 оноос тогтворжих хандлагатай болж, улмаар 2009 онд 43.8 хувь болтлоо буурсан хэдий ч сүүлийн жилүүдэд нийслэлд үйл ажиллагаа явуулахаар шинээр зөвшөөрөл авсан сүм хийдийн дунд эзлэх христийн сүмүүдийн тооны харьцаа огцом өөрчлөгдөж, 2010 онд 69.0 хувь, 2011 онд 77.3 хувь хүртлээ өссөн байна.

Хүснэгт 4. Шинээр байгуулагдсан сүм хийд, шашны төрөл, дүүргээр, 2010, 2011 оны эцэст

Дүүрэг	Бүгд		Шашны төрлөөр:						
	2010	2011	Будда		Христ		Католик		Бөө
			2010	2011	2010	2011	2010	2011	2010
Багануур	-	1	-	1					
Баянгол	3	1	1		2	1			
Баянзүрх	15	3	1		13	3			1
Сонгинохайрхан	4	9	1		2	9			1
Сүхбаатар	13	6	5	3	7	2		1	1
Хан-Уул	1	2				2	1		
Чингэлтэй	6	-	1		5				
Нийслэлийн дүн	42	22	9	4	29	17	1	1	3

2012 оны 11-р сарын 1-ний байдлаар нийслэлд сүм хийд шинээр байгуулахад зөвшөөрөл олгосон тухай тогтоол НИТХ-ын Тэргүүлэгчдээс гаргаагүй байгаа тул 2011 оны жилийн эцсийн дүнгээр энэхүү мэдээллийг бэлтгэсэн билээ.

2010 онд НИТХ-ын Тэргүүлэгчдээс шашны байгууллагын талаар нийт 6 тогтоол гаргаж, түүнээс 3 удаагийн тогтоолоор 42 сүм хийдэд шинээр зөвшөөрөл олгосон байдаг. Эдгээр сүмийн 15 нь Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байршдаг бөгөөд 86.7 хувь буюу 13 нь “христийн” сүм байгаа юм. Мөн Сүхбаатар дүүрэгт 13 сүм хийдэд зөвшөөрөл олгогдсон байгаагийн 7 нь буюу 53.8 хувийг христийн сүмүүд эзэлж байна. 2011 оны хувьд ч мөн адил 6 тогтоол гарчээ. Гэтэл оны сүүлийн сард хуралдсан хуралдаанаараа буюу 2011 оны 12-р сарын 7-ны өдрийн 185-р тогтоолоор зургаан дүүрэгт нийтдээ 22 сүм хийдэд нэг дор шинээр зөвшөөрөл олгож, 11 шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгасан байв.

Уг тогтоолын дагуу шинээр байгуулагдсан эдгээр сүм хийдийн 77.3 хувь нь христийн, тэр дундаа 52.9 хувь нь Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл олгогдсон байна. Ялангуяа нэгэн зэрэг зөвшөөрөл авсан христийн 9 сүм бүгдээрээ зөвхөн нэг дүүргийнх байгаа нь анхаарал татахгүй байхын аргагүй зүйл юм.

Сүм хийд шинээр байгуулахад зөвшөөрөл олгох, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгах аль ч тохиолдолд зөвшөөрөл хүчинтэй байх хугацаа гол төлөв нэг жил байдаг. Гэхдээ 1990-ээд оны эхэн үед зарим сүм хийдэд олгосон зөвшөөрлийн хүчинтэй хугацааг “байнга” гэсэн тодотголтойгоор тогтоож байжээ.

Мөн цөөн тохиолдолд зарим нэг сүм хийдийн зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгасан тохиолдол бий. Тухайлбал, Баянзүрх дүүрэгт байрлах христийн “Сайн үйлс” сүмд 2004 онд, Чингэлтэй дүүргийн Дотоку Кайкан буддын хийдэд 2008 онд, мөн дүүргийн Бакула Ринбүчигийн “Бэтүб Данжай Чойнхорлин” хийдэд олон улсын түвшинд явуулж буй хамтын ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны цар хүрээг нь харгалзан 2010 онд зөвшөөрлийг нь 3 жилийн хугацаатай сунгаж байсан байна.

Зураг 3. “Байнга”-ын үйл ажиллагаатай сүм хийд, дүүргээр



Нийслэлд шашны үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөлтэй 247 сүм хийдийн 8.5 хувь буюу 21 сүм хийдийн зөвшөөрлийн хүчинтэй хугацаа байнга байхаар тогтоогдсон байдаг. Ийм зөвшөөрөлтэй сүм хийдийн тоо 1990-ээд оны сүүл үе гэхэд нийтдээ 28 байсан боловч явцын дунд 7 сүм хийдийн зөвшөөрлийн хугацаанд өөрчлөлт орж, эдгээрээс 6 сүм хийдийн зөвшөөрлийн хугацаа нэг жил (Бэтүб хийдээс бусад)

тутамд сунгалт хийлгэх нөхцөлд шилжсэн байна. Дээр дурдсан 6 шашны байгууллага бүгд христийн сүмүүд байгаа бөгөөд Баянгол, Чингэлтэй дүүрэгт тус бүр нэг, дөрөв нь Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 4. Зөвшөөрлийн хугацаа нь дууссан сүм хийд, дүүргээр



2011 оны жилийн эцсийн байдлаар НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолд заасан шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа нь дууссан 85 сүм хийд байна. Тэдгээрийн 57.6 хувь нь буддын, 29.4 хувь нь христийн, 11.8 хувь нь бөөгийн, 1.2 хувь нь католик шашин байгаа бөгөөд олонх нь Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт бүртгэлтэй ажээ.

Энэ бүх мэдээлэл нь манай нийслэл хотод уламжлалт бурханы шашин болоод гадаадын шашны байгууллага хоорондын тооны зохистой харьцаа тэнцвэртэй биш байдалд ороод зогсохгүй, улмаар сүм хийдийн байршил, шашны үйл ажиллагаа явагдах нутаг дэвсгэрийн нэгжид тавих хяналт алдагдаж, нийслэлийн нутгын өөрөө удирдах ёсны байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт ч илт суларсан гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.

Шашин шүтлэгийн асуудал нийгмийн оюун санааны амьдралын хамгийн эмзэг бөгөөд нарийн түвэгтэй үзэгдлийг тусгаж байдаг. Зүй зохистой хэмжээндээ байвал нийгмийн харилцааг энэрэнгүйжүүлэх, өсвөр залуу үеийг хүмүүжүүлэх, нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх зэрэгт олон сайн нөлөөтэй. Харин шашин шүтлэгээр бүлэглэн хуваагдаж, өөр хоорондоо сөргөлдөн тэмцэлдэх замаар зөрчил үүсвэл бүлэглэл хоорондын мөргөлдөөн, цаашлаад хямралд хүргэж болох осолтой талтай.

Монгол Улс 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн хүрээнд хүний эрх, эрх чөлөө баталгаажсаны дотор шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө мөн нээлттэй болсон. Иргэн хүн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэх боломж бүрдэж төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулж өгсөн явдал нь ардчиллын томоохон ололтуудын нэг байв.

Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хуульд “Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна”³ гэж заасан.

Хүн амын шашин шүтлэгийн талаарх мэдээлэл манай улсад зохион байгуулагдсан өмнөх тооллогуудын асуулгад огт тусгагдаж байгаагүй. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогод “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ?” гэсэн асуултыг “арван тав, түүнээс дээш насны хүн ам”-аас асуусан нь уг тооллогын нэг онцлог байсан.

³ Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль. Монгол Улсын хуулийн эмхтгэл. IV боть, Улаанбаатар хот, 2008 он, хуудас 541.

Хүснэгт 5. Хүн амын шашин шүтлэгийн байдал, шашны төрөл, насны бүлгээр, 2010 он


	15, түүнээс дээш насны	Шашин шүтдэг	Үүнээс: Шашны төрлөөр					Дүнд эзлэх хувь	Шашин шүтдэггүй	
			Будда	Христ	Ислам	Бөө	Бусад			
15, түүнээс дээш насны хүн ам - Бүгд	871860	535397	463009	26535	5901	36436	3516	61.4	336463	
Насны бүлэг	15-19	121019	63756	52315	4447	1256	5347	391	52.7	57263
	20-24	159643	92023	76242	5408	1819	7879	675	57.6	67620
	25-29	116322	70245	59886	3391	662	5775	531	60.4	46077
	30-34	97609	60100	52641	2383	512	4161	403	61.6	37509
	35-39	86563	54611	47913	2491	398	3473	336	63.1	31952
	40-44	74127	47258	41318	2199	330	3089	322	63.8	26869
	45-49	67613	43770	38277	2149	302	2765	277	64.7	23843
	50-54	52379	35102	31198	1604	218	1865	217	67.0	17277
	55-59	31323	21402	19274	952	120	926	130	68.3	9921
	60-64	22676	16127	14868	592	89	490	88	71.1	6549
	65-69	16605	11876	11035	408	78	302	53	71.5	4729
70+	25981	19127	18042	511	117	364	93	73.6	6854	

Тооллогын дүнгээр нийслэлийн арван тав, түүнээс дээш насны хүний тоо 871.9 мянгад хүрсэн бөгөөд 38.6 хувь нь ямар нэгэн шашингүйчүүд, 61.4 хувь нь буюу 535.4 мянган хүн шашин шүтэж байгаагийн 86.5 хувь нь буддын шашинтан байв.

Хүснэгт 6. Хүн амын шашин шүтлэгийн байдал, шашны төрөл, хүйс, хувиар, 2010 он

Шашны төрөл	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд:	100.0	100.0	100.0
Шүтдэггүй	38.6	43.1	34.5
Шүтдэг	61.4	56.9	65.5
Будда	53.1	49.5	56.4
Ислам	0.7	0.7	0.6
Бөө	4.2	3.9	4.4
Христ	3.0	2.4	3.7
Бусад	0.4	0.4	0.4

Зураг 5. Шашин шүтдэг хүн ам, шашны төрөл, хувиар, 2010 он



Шашин шүтдэг хүн амын тоог шүтдэг шашны төрлөөр авч үзэхэд 93.3 хувь нь бурханы шашин болон бөө мөргөлийг шүтдэг байна. Шашин шүтлэгтэй хүн амын 42.2 хувийг 15-30 хүртэлх насны залуучууд эзэлжээ. Улмаар хүн амын нас ахих тутам тухайн насны нийт хүн амд шашин шүтдэг хүн амын эзлэх хувь нэмэгдэж байна. Тухайлбал, 15-19 насны хүүхэд залуучуудын 52.7 хувь шашин шүтдэг байхад 35-39 насныхны 63.1 хувь, 45-49 насны хүн амын 64.7 хувь, 55-59 насныхны 68.3 хувь, 70-аас дээш насны хүн амын 73.6 хувь нь шашин шүтдэг байна.

Христийн болон бусад шашин шүтэх явдал 1990-ээд оноос өмнө үндсэндээ байгаагүй бол өнөөгийн монголчуудын оюун санааны амьдралд гадны шашны урсгал, чиглэл нэвтрэх болсон. Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор нийслэлийн 26.5 мянган иргэн христийн шашинтан байгаа нь арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 3.0 хувийг эзэлж байв. Шашин шүтдэг хүн амын дотор эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс илүү олон байгаа юм. Шашин шүтдэг нийт эмэгтэйчүүдийн 5.6 хувь буюу 16.7 мянган эмэгтэй христийн шашинтан байна.

Хүснэгт 7. Шашин шүтдэг хүн ам, насны бүлэг, шашны төрөл, хувиар, 2010 он

Насны бүлэг	Шашинтан	Будда	Христ	Ислам	Бөө	Бусад
Бүгд:	100.0	86.5	5.0	1.1	6.8	0.6
15-19	100.0	82.0	7.0	2.0	8.4	0.6
20-29	100.0	84.0	5.4	1.5	8.4	0.7
30-39	100.0	87.7	4.2	0.8	6.7	0.6
40-49	100.0	87.4	4.8	0.7	6.4	0.7
50-59	100.0	89.4	4.5	0.6	4.9	0.6
60-69	100.0	92.5	3.6	0.6	2.8	0.5
70+	100.0	94.3	2.7	0.6	1.9	0.5
Дүн:	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-19	11.9	11.3	16.8	21.3	14.7	11.1
20-29	30.3	29.4	33.2	42.0	37.5	34.3
30-39	21.4	21.7	18.4	15.4	21.0	21.0
40-49	17.0	17.2	16.4	10.7	16.0	17.0
50-59	10.6	10.9	9.6	5.7	7.6	9.9
60-69	5.2	5.6	3.8	2.8	2.2	4.
70+	3.6	3.9	1.8	2.1	1.0	2.6

Нийслэлийн арван тав, түүнээс дээш насны суурин хүн амын зонхилох хувийг эзэлж буй 20-24 насны залуучуудын 57.6 хувь, түүний дотор эрэгтэйчүүдийн 54.5 хувь, эмэгтэйчүүдийн 60.6 хувь нь шашин шүтдэг байна. Шашин шүтдэг хүн амын 51.7 хувь нь 20-39 насныхан байгаа бөгөөд шашны төрлөөр уг үзүүлэлтийг авч үзвэл буддын шашинтнуудын 51.1 хувь, бөөгийн шашинтнуудын 58.5 хувь, исламын шашинтнуудын 57.4 хувь, христийн шашинтнуудын 51.6 хувийг 20-39 насныхан эзэлж байгаа юм.

Шашин шүтдэг хүн амын нас ахих тутам монголын уламжлалт буддын шашинг илүүтэй шүтдэг байна. Тухайлбал, 15-19 насны шашинтнуудын 82.0 хувь нь будда шүтэж байхад 50-59 насныхны 89.4 хувь, 60-69 насныхны 92.5 хувь, 70, түүнээс дээш насныхны 94.3 хувь нь буддын шашинтан байна. Нөгөө талаар христийн шашинтан хүн амын эзлэх хувь шашин шүтдэг хүн амын нас ахих тутам буурч байгаа юм. Тухайлбал, 15-19 насны шашин шүтдэг хүн амын 7.0 хувь нь христийн шашинтан байхад 60-69 насанд 3.6 хувь, 70 ба түүнээс дээш насанд 2.7 хувь болж буурч байна. Христийн шашинтан гурван хүн тутмын нэг нь 20-29 насныхан байгаа бол 18.4 хувь нь 30-39 насны, 16.8 хувь нь 15-19 насны, 16.4 хувь нь 40-49 насныхан байна. Түүнчлэн нийслэлийн арван тав, түүнээс дээш насны 3.5 мянган хүн бахай шүтлэг, мүүний гэх мэт бусад шашин шүтдэг ажээ.



Уламжлалт бурханы шашныг шүтэх явдал урьд үеийнхтэйгээ харьцуулахад үлэмж сэргэсэн. Монголчууд бидний зонхилон шүтдэг шашин нь Түвдийн буддизмын шарын шашин (шар малгайтны ёс) бөгөөд бурханы шашны их хөлгөний ёсонд багтдаг. Дотроо шарын ёсны буюу "гэлүгла", улааны ёсны буюу "нямаава", "гармаава", "сажаава" гэсэн нийтдээ дөрвөн урсгалтай. Буддын шашин нь үйл ажиллагаа, зохион байгуулалтын хэв шинжээрээ сүм хийд ба сект маягийн, үйл ажиллагааны чиглэлээрээ мамба, зурхай, чойрын, зодын хэмээн ангилагддаг байна.

Будда ("гэгээрсэн") хэмээх нэр томъёо нь нэр бус цол юм. Буддын шашинтнууд хязгааргүй олон будда байсан, ирээдүйд ч олон будда газар дэлхийд заларна гэж итгэдэг.

Бөө (*shaman*) Бөө мөргөл нь манай орны иргэдийн хувьд уламжлалт шашных нь нэг билээ. Өвчнийг эдгээх, үл мэдэхийг зөгнөх, үйл явдлыг удирдах зорилгоор ид шид хэрэглэдэг хүнийг бөө гэж нэрлэдэг. Эрэгтэй, эмэгтэй ямар ч хүн бөө байж болдог. Бөөгийн шашинг эрт үед зөвхөн Арктик ба Төв Азийн ард түмэнтэй холбон авч үздэг байсан бол өнөө үед дэлхий даяар уг нэр томъёогоор төстэй шашин юмуу шашин маягийн тогтолцоог нэрлэх болсон.

Бөө нь анагаагч, домч болохын хувьд өвчнийг эдгээж, олон нийтэд зориулсан тахил өргөх явдлыг удирдаж, нас барсан хүний сүнснийг хойд насанд нь үдэж өгдөг. Тэрээр энэ бүхнийг онгод орсон байх үед буюу биеэ "орхин гарах хүч"-ийг ашиглан хийдэг.

Бөөгийн шашинтай соёлд өвчнийг сүнс төөрсний шинж гэж үздэг тул бөө хүн сүнсний ертөнц рүү нэвтрэн, төөрсөн сүнснийг барин биенд эргүүлэн авчрах үүрэгтэй. Бөө хүн удам дамжин, мөн өөрөө өөрийгөө тодруулах замаар төрдөг байна.



Манай орны казах иргэдийн хувьд уламжлалт шашин шүтлэг нь исламын шашин бөгөөд 1990 оны 10 сард Монголын мусульманы нийгэмлэг байгуулагдаж, 1992 онд болсон хурлаараа нийгэмлэгийнхээ нэрийг өөрчлөн "Монголын ислам шашны төв" хэмээн нэрлэх болжээ.



Монголын христ шүтлэгтнүүдийн сүм "Ертөнцийн эзний чуулган" нэртэйгээр анх 1990 оны 10 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн ням гариг бүрийн цугларалт зохион байгуулж, үйл ажиллагаагаа эхэлснээр энэ шашны нөлөө нийгэмд тархах болж, богино хугацаанд хэдэн мянган дэмжигч, сүсэгтнүүдтэй болсон.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй христийн шашны байгууллагууд нь дотроо ялгамжтай өөр өөр урсгал, чиглэлийг төлөөлж байдгаараа онцлог юм. Тухайлбал, эдгээрээс протестант урсгалыг баримтлагч сүмүүд зонхилж, албан ёсны зөвшөөрөлтэй христийн шашны 47.3 хувийг эзэлж байна. Түүнчлэн 25.8 хувь нь эвангел урсгалын чиг баримжаатай ажилладаг бол 6.4 хувь нь баптист, 5.7 хувь нь методист, 4.3 хувь нь пентикост урсгалыг төлөөлдөг байна. Эдгээрээс гадны адвентист урсгал цөөвтөр, харин үнэн алдартны болон христ мормон чиглэл тус бүр нэг ажиллаж байна.

Лавлагаа 1.

Буддын шашин (*Buddhism*) Буддын шашин зовлон, дахин төрөл авах орчлоос ангижирч нирваанд хүрэхийг эрхэмлэдэг. Үүний тулд бясалгал хийж, ёс суртахууны зарчим баримталдаг.

Буддын шашны гол хоёр уламжлал болох их, бага хөлгөнүүд өөр өөрийн шүтлэгийн зан үйл болоод ариун судартай болон хөгжжээ. Буддын шашин өмнө зүгт дэлгэрэн Шри-Ланк, Зүүн өмнөд Азид цэцэглэн хөгжсөн ба Төв Ази болон Хятадаар дамжин Солонгос, Японд нэвтэрсэн. XIX зуунд буддын шашин Европ, АНУ-д тархаж, XX зууны II хагаст Баруунд маш их түгэн дэлгэрсэн. XXI зууны эхэн үед буддын шашны өөр өөр уламжлалыг дагадаг нийт 375 сая гаруй хүн байгаа ажээ.

Britannica ширээний нэвтэрхий толь, 1 531 дэх тал

Ер нь христийн шашин олон урсгал, чиглэлтэй бөгөөд тэдгээрийн нэг хэсэг нь дунд үе буюу протестантизмын үеийн ба XVIII-XIX зууны үед үүссэн байхад нөгөө нэг хэсэг нь XX зууны эхээр болон дундуур үүсэн хожуу үеийн урсгалууд ч байдаг. Эдгээр нь өөр хоорондоо нийгэм, улс төрийн чиг баримжаа, сургаал номлолын тайлбарлал ба эх сурвалжаараа, тахил шүтээний ёс, заншил уламжлалаараа ялгагдах бөгөөд эл ялгаа нь өчүүхэн төдий үл ялгах байдалтай байхаас эхлээд бүр эрс тэс, харилцан үгүйсгэх хүртэл янз бүрийн хэмжээ хүрээтэй байх нь ажиглагддаг.

Нийслэл Улаанбаатар хотод төдийгүй монгол орны хөдөө орон нутагт христийн шашин хүрээгээ тэлж буй үйл явц нь түүхийн хувьд шинэ зүйл биш боловч өнөөгийн нөхцөл байдал, нийгмийн учир холбогдлын талаас нь авч үзвэл харьцангуй шинэхэн үзэгдэл юм.



Үзэл санаа, сургаал номлолын агуулга, үйлдэл шүтлэгийнхээ шинжээр өмнө дурдсан дэлхий дахины шашнуудын аль нэг төрөлд хамрагддаггүй цаг хугацааны хувьд тэднээс эрс хожуу үүссэн шашны урсгалуудыг шинэ шашинд хамруулдаг. Эдгээрийн нэг нь бахайн шашин юм. “Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулган” нэртэйгээр анх 1998 онд үүсгэн байгуулагдсан. Нийслэлд шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг нь “байнга” гэсэн тодотголтойгоор НИТХ-ын Тэргүүлэгчдээс тогтоож өгсөн байдаг.



Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа сүм хийдийн хамгийн отгон төлөөлөл нь японы уугуул шашин болох Ками хэмээх сүнсийг тахин шүтэхэд үндэслэгдсэн “шинто” шашин юм.

Ийнхүү баримталдаг чиглэл, номлол сургаалийн талаас нь авч үзэхэд 5-6 төрлийн шашинд хамаарах 10 гаруй урсгал чиглэлийг төлөөлсөн уламжлалт бус шашны байгууллагууд нийслэлд байршин үйл ажиллагаа явуулж байна.

Лавлагаа 2.

Христийн шашин (*Christianity*) Есүсийн сургаалд үндэслэн МЭ I зуунд үүссэн шашин. Ариун судар нь Библи, тэр дундаа Шинэ гэрээ. Энэ шашин Есүс бол Бурханы хүү (Ариун гурвал-ын хоёр дахь бодгал), Бурханы хайр бүтээсэн ертөнцийнхөө оршин байх үндэс болдог, хүн төрөлхтний нүглийг цайруулахын төлөө Есүс үхсэн гэдэг үндсэн номлолтой. Христийн шашин эхэндээ Есүсийг аврагч мэтээр хүлээн авсан жүүдийн хөдөлгөөн байсан ч төдөлгүй харь үндэстэн зонхилсон хөдөлгөөн болжээ.

Гэгээн Паул, христийн шашин дэлгэрүүлэгчид, теологичид энэ шашны хуучин хэв маягийг буй болгосон. Энэ шашныг Ромын Эзэнт Улсад хяхаж хавчиж байсан ч Константин I христийн шашинд орсон анхны эзэн хаан болсноор дэмжих болсон. Ромын католик, үнэн алдартны, протестант шашин нь христийн шашны томоохон салбар юм. Христийн бараг бүх сүмд сахил хүртсэн ихэвчлэн эрэгтэй хуврагууд байдаг. Санваартнууд нийтээрээ мөргөл үйлддэг, зарим сүмд тэднийг сүсэгтэн болон тэнгэрийн хоорондох зуучлагч гэж үздэг. Ихэнх христийн сүм загалмайлах, евхарист зан үйлийг гүйцэтгэдэг. XXI зууны эхэн үеийн байдлаар бүх тивийг оролцуулаад дэлхий даяар хоёр тэрбум гаруй христийн сүсэгтэн байна.

Britannica ширээний нэвтэрхий толь, 7

Лавлагаа 3.

Бахайн шашин Баха Улла XIX зууны дундуур Иранд үүсгэсэн шашны урсгал. 1863 онд Баха Улла өөрийгөө Баб урьдчилан зөгнөсөн, Аллахын илгээсэн элч хэмээн зарласнаар бабизмаас тусгаарласан. 1892 онд Баха Улла нас барахаасаа өмнө өөрийн хүү абд ол-Бахуг хүй хамтлагийнхаа тэргүүнээр зарлажээ. Мөргөл үйлдэхдээ бүх шашны ариун судруудаас уншдаг.

Бахайн шашинтнууд бүх шашин дотоод мөн чанараараа адил бөгөөд хүн төрөлхтөн ч нэгдмэл гэж тунхагладаг. Тэд нийгмийн ёс суртахуунд анхаарал хандуулдаг бөгөөд хувраг санваартан болон шашны ямар нэг нууц зан үйлгүй. Анх энэ сургаалыг 19 хүн дагасан болохоор энэ тоог ариун гэж үздэг ба тус бүр 19 хоногтой, (нэмэлт дөрвөн өдөр) 19 сартай хуанлитай. Сүсэгтнүүд нь өдөр бүр мөргөл үйлдэх ба жилд 19 хоног зан суртлын хатуу дүрэм бүхий сахил сахидаг. 1960-аад оноос бахайн шашинд орогсод илт нэмэгдсэн боловч 1979 онд хуучинсаг үзэлтнүүд хувьсгал хийснээс хойш Иранд тэднийг мөрдөж мөшгих болсон.

*Britannica ширээний нэвтэрхий толь, 1
363 дахь тал*